



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.03.14 № 50
танай _____-ны № _____-т

“ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ
ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус компани нь тайлант онд Бүгд Найрамдах Хятад Ард улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн “Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөлийн төсөл”-ийн хүрээнд бий болсон 53 нэр төрлийн нийт 202,531.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/12 дугаар тушаалаар “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөө”-г батлуулсан бөгөөд тайлант онд 2 удаа тодотгол хийсэн байна.

612505490

Бусад асуудлын хэсэг

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2026/004/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:

www.audit.mn

Эрдэнэт хот

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва

Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: Ц.Одгэрэл

Утас: 70357955 Цахим хаяг: odgereits@audit.gov.mn

Аудитор: О.Гантуяа

Утас: 70357955 Цахим хаяг: gantuyao@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	8
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Төлбөрийн акт.....	16
5.2 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.03.14 № 30
танай -ны № -т

“ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ
ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус компани нь тайлант онд Бүгд Найрамдах Хятад Ард улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн “Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөлийн төсөл”-ийн хүрээнд бий болсон 53 нэр төрлийн нийт 202,531.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/12 дугаар тушаалаар “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөө-г батлуулсан бөгөөд тайлант онд 2 удаа тодотгол хийсэн байна.

612503490

Бусад асуудлын хэсэг

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх ~~үндэслэлтэй~~ байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.НҮРЭВЛХАГВА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,127,762,713.71	502,191,765.06
1.1.2	Дансны авлага	5,254,108,740.61	11,008,983,363.81
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	350,526,126.46	552,321,733.80
1.1.6	Бараа материал	5,452,218,624.85	4,262,101,284.73
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	179,781,771.23	995,451.45
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	12,364,397,976.86	16,326,593,598.85
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	69,516,309,807.94	274,380,577,693.79
1.2.2	Биет бус хөрөнгө	21,192,520,530.22	21,179,284,914.51
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	90,708,830,338.16	295,559,862,608.30
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	103,073,228,315.02	311,886,456,207.15
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	8,380,580,415.10	14,792,393,974.08
2.1.1.2	Цалингийн өглөг	4,042,361,896.51	4,575,568,232.35
2.1.1.3	Татварын өр	193,021,179.60	166,047,907.38
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	4,431,524,274.77
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	61,216,936.57	30,673,324.54
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	2,000,000,000.00	38,182,964,455.84
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	855,273,171.00	4,367,443,336.36
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	15,532,453,600.78	66,546,615,505.32
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	163,525,359,202.50
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	807,716,570.81	1,025,544,097.10
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	807,716,570.81	164,550,903,299.60
2.2	Өр төлбөрийн нийт дүн	16,340,170,171.59	231,097,518,804.92
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	19,447,456,792.53	19,447,456,792.53
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	59,135,050,898.37	59,135,050,898.37
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	21,055,553,000.00	21,055,553,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-12,905,002,547.47	-18,849,123,288.67
2.3.11	Эздийн өмчийн дүн	86,733,058,143.43	80,788,937,402.23
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	103,073,228,315.02	311,886,456,207.15

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	83,692,225,663.70	97,494,004,072.42
2	Борлуулалтын өртөг	80,828,099,064.91	94,952,654,567.95
3	Нийт ашиг (алдагдал)	2,864,126,598.79	2,541,349,504.47
4	Түрээсийн орлого	35,371,176.16	33,771,161.62
5	Хүүгийн орлого	23,758,251.21	24,147,091.81
6	Бусад орлого	6,888,782,971.61	488,334,265.11
7	Борлуулалт, маркетингийн зардал	6,663,214,695.22	7,281,025,011.65
8	Ерөнхий ба удирдлагын зардал	1,794,644,998.85	2,252,954,944.25
9	Бусад зардал	1,040,756,988.25	333,682,027.47
10	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	0.00	835,939,198.96

11	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	313,422,317.67	-5,944,120,741.20
12	Орлогын татварын зардал	46,873,272.22	0.00
13	Татварын дараах ашиг (алдагдал)	266,449,045.45	-5,944,120,741.20
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	266,449,045.45	-5,944,120,741.20
16	Орлогын нийт дүн	266,449,045.45	-5,944,120,741.20

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000.00	-13,021,256,064.20	86,498,964,626.70
Запуулсан үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000.00	-13,021,256,064.20	86,498,964,626.70
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	117,840,000.00	0.00	117,840,000.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	-150,195,528.72	-150,195,528.72
Тайлант үеийн цэвэр ашиг	0.00	0.00	0.00	266,449,045.45	266,449,045.45
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	38,894,913,585.06	118,270,101,796.74	42,111,106,000.00	-25,810,005,094.94	173,466,116,286.86
Запуулсан үлдэгдэл	38,894,913,585.06	118,270,101,796.74	42,111,106,000.00	-25,810,005,094.94	173,466,116,286.86
Тайлант үеийн цэвэр ашиг	0.00	0.00	0.00	-5,944,120,741.20	-5,944,120,741.20
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	19,447,456,792.53	59,135,050,898.37	21,055,553,000.00	-18,849,123,288.67	80,788,937,402.23

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	83,918,690,229.56	88,323,075,889.21
1.1.1	Борлуулалтын болон худалдан авагчаас орсон мөнгө	76,952,352,522.28	88,113,513,931.04
1.1.2	Туслах үйл ажиллагаанаас орсон мөнгө	0.00	26,951,715.93
1.1.4	Бусад мөнгөн гүйлгээ	6,969,337,707.60	182,610,212.24
1.2	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	75,078,741,467.46	83,635,616,660.21
1.2.1	Ажиллагчдад олгосон мөнгө	18,818,997,985.23	23,132,826,129.51
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	5,653,585,722.80	6,380,756,074.91
1.2.3	Түүхий эд, материал худалдан авахад төлсөн мөнгө	37,478,790,788.36	39,576,238,126.20
1.2.4	Ашиглалтын зардалд	157,862,794.74	254,847,167.44
1.2.5	Түлш шатахуун тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	7,049,879,466.23	6,924,400,737.11
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	617,095,030.75	212,573,493.97
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	4,789,083,818.83	4,689,741,667.11
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	11,202,256.00	14,000,000.00
1.2.9	Бусад үйл ажиллагааны мөнгөн зардал	502,243,604.52	2,450,233,263.96
1.2	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,839,948,762.42	4,687,459,199.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.2	Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	6,509,028,782.50	6,398,345,842.20
2.2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	6,509,028,782.50	6,398,345,842.20
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.2	Банкнаас авсан зээл	1,400,000,000.00	3,980,000,000.00
3.4	Зээлийн төлөлт	-3,000,000,000.00	-2,918,831,397.26

3.9	Мөнгөөр төлсөн ноогдол ашиг	-150,195,528.72	0.00
3.1	Хүү ба урамшууллын орлого	23,758,251.21	24,147,091.81
3.2	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,750,195,528.72	1,085,315,694.55
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	604,482,702.41	-625,570,948.65
4.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	523,280,011.30	1,127,762,713.71
4.2	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,127,762,713.71	502,191,765.06

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 оны тодотгосон төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
		х	2	3	4=3-2	
1	Үйлдвэрлэсэн: Цахилгаан эрчим хүч	мян.квтц	465,567.81	464,875.14	-432.67	98.5%
	Үйлдвэрлэсэн: Дулааны эрчим хүч	Гкал	703,170.91	703,786.00	615.09	
	ДХЦЭХ	хувь	14.04%	14.66%	0.62%	
	Биегээр	мян.квтц	56,902.1	59,336.7	2,434.7	
	Түгээсэн: Цахилгаан эрчим хүч	мян.квтц	348,405.7	345,538.4	-2,867.32	
2	Түгээсэн: Дулааны эрчим хүч	Гкал	651,688.6	651,801.0	112.4	101.6%
	Нийт орлого	мян.төг	97,350.88	98,876.20	1,525.32	
	Үүнээс: Үйл ажиллагааны орлого	сая.төг	97,159.09	97,494.00	334.91	
	Бус орлого	сая.төг	191.78	1,382.19	1,190.41	
	Нийт зардал	сая.төг	111,825.51	104,820.32	-7,005.29	
3	Үндсэн үйл ажиллагааны зардал	сая.төг	111,346.11	104,486.63	-6,859.48	106.7%
	Үүнээс: Түлш	сая.төг	42,354.76	40,584.38	-1,770.39	
	Элэгдэл	сая.төг	10,515.15	9,900.30	-614.85	
	Бусад тогтмол	сая.төг	58,476.20	54,001.96	-4,474.24	
	Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	479.50	333.68	-145.82	
4	Татварын өмнөх ашиг/алдагдал	сая.төг	-14,474.73	-5,944.12	8,530.61	243.5%
5	Татварын дараахь ашиг/алдагдал	сая.төг	-34,474.73	-5,944.12	28,530.61	243.8%
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.15	1.06	-0.09	108.4%
7	Нийт авлага	сая.төг	818.9	11,561.3	10,742.4	7.1%
	Үүнээс: ЭХ-ний	сая.төг	818.9	10,025.9	9,207.0	
	бусад	сая.төг		1,535.4	1,535.4	
8	Нийт өглөг	сая.төг	188,000.5	231.1	-187,769.40	81.4%
	Үүнээс: Богино хугацаат өр төлбөр	сая.төг	11,300.5	66.5	-11,233.95	
	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	176,700.0	164.6	-176,535.45	
9	Нийт ажиллагсад	хүн	473	471	-2.00	99.6%
10	Нийт цалингийн сан	сая.төг	26,330.6	26,229.2	-101.43	100.4%
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	гр/кВт.ц	406.54	404.47	-2.07	100.4%
	ДЭХ	кг/Гкал	187.44	187.04	-0.40	
12	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт	сая.төг	11,885.6	10,782.4	-1,103.10	96.2%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн зорилго нь Орхон аймгийн иргэдийг дулаан, цахилгаан эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахилгаан үйлдвэрлэх
- Дулаан үйлдвэрлэх
- Дулаан түгээх
- Дулаанаар зохицуулалттай хангах
- Эрчим хүчний тоног төхөөрөмж, даралтат сав шугам хоолойг ашиглах, засвар үйлчилгээ хийх
- Хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх.

Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг 12 зорилтын хүрээнд төлөвлөснөөс 7 үзүүлэлт давж, 3 үзүүлэлт бүрэн хэрэгжиж, 2 үзүүлэлт 7-81 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийг Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 164 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулж, компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч буюу компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор томилдог байна.

Тус компани нь тайлант онд үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажилласан байна. Үүнд:

- ✓ Компанийн тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль
- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✓ Шилэн дансны тухай хууль
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✓ Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- ✓ Нийгмийн даатгалын тухай багц хууль
- ✓ Эрчим хүчний тухай хууль
- ✓ Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
- ✓ Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- ✓ Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн тогтох тухай”
- ✓ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дугаар тушаал “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”

- ✓ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаал "Дундаж цалин хөлс тодорхойлох журам".

Тайлант онд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн "Тариф батлах тухай" 71 дүгээр тогтоол,
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн "Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах нүүрсний үнийг хянах тухай" 167 дугаар тогтоол,
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн "Төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай" 483 дугаар тогтоол тус тус батлагдсан байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна гэж үзлээ.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

Тайлант онд тус компанийн бизнес төлөвлөгөө, гүйцэтгэл болон санхүүгийн үйл ажиллагаанд харьяалах дээд байгууллага Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2015 онд баталсан бөгөөд тухайн үед мөрдөгдөж байсан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч байгаа хэдий ч 2016-2025 онд шинэчлэгдсэн хууль, журам, стандартын өөрчлөлтийг тусгаж шинэчлээгүй тул өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчилж батлуулах" зөвлөмж өгсөн боловч тайлант онд хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлээ.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 208,813.2 сая төгрөгөөр буюу 202.6 хувиар өсжээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,127.76	562.19	(625.57)
Авлага	5,254.11	11,008.98	5,754.87
Татвар, НДШ-ийн авлага	350.53	552.32	201.80
Бараа материал	5,452.22	4,262.10	(1,190.12)
Урьдчилж төлсөн зардлын тооцоо	179.78	1.00	(178.79)
Үндсэн хөрөнгө	69,516.31	274,380.58	204,864.27
Биет бус хөрөнгө	21,192.52	21,179.28	(13.24)
Нийт хөрөнгө	103,073.23	311,886.46	208,813.23
Богино хугацаат өр төлбөр	15,532.45	66,546.62	51,014.16
Урт хугацаат өр төлбөр	807.72	164,550.90	163,743.19
Эздийн өмч	86,733.06	80,788.94	(5,944.12)
Өр төлбөр ба эздийн өмч	103,073.23	311,886.46	208,813.23

Нийт хөрөнгө өмнөх оноос 208,813.2 сая төгрөгөөр өсөхөд авлага 5,754.9 сая төгрөг, үндсэн хөрөнгө 204,864.3 сая төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлжээ.

Авлагын дансны үлдэгдэл 11,561.3 сая төгрөг болж, өмнөх оноос 5,956.7 сая төгрөгөөр өсөхөд Диспетчерийн үндэсний төв ХХК-д худалдсан цахилгаан эрчим хүчний авлага 9,459.7 сая төгрөг буюу 81.8 хувийг эзэлж буй нь гол нөлөө үзүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 4,262.1 сая төгрөг болж, өмнөх оноос 1,190.1 сая төгрөгөөр буурсан нь бараа материалын судалгааг сүүлийн таван жилээр, насжилт, өртөг, үлдэгдлээр тус тус гарган бараа материалын кодчиллыг шинэчлэн, илүүдэл, дутагдлын тайланг гаргаж санхүүгийн тайланд тусган, бараа материалыг зөвхөн шаардах хуудсаар бус нормтой уялдуулан олгож эхэлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 274,380.6 сая төгрөг болж, 204,864.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн "Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөлийн төсөл"-ийн хүрээнд бий болсон 53 нэр төрлийн нийт 202,531.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгасан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэл өмнөх оноос 51,014.2 сая төгрөгөөр өсөж, 66,546.6 сая төгрөг болсон байна. Энэ нь "Шарын гол" ХК-д төлөх нүүрсний өглөг 4,015.8 сая төгрөг, бэлтгэн нийлүүлэгчийн өглөг 2,015.9 сая төгрөг, тухайн жилийн хөрөнгө оруулалтын дагуу олгох 6,591.4 сая төгрөгийн өглөг, цалингийн өглөг 4,575.6 сая төгрөг, Голомт банкнаас авсан зээлийн өглөг 2,980.0 сая төгрөг, өргөтгөлийн зээлийн төлбөр 10.7 сая ам.доллар буюу 38,183.0 сая төгрөг, хүүгийн төлбөр 1.2 сая ам.доллар буюу 4,431.5 сая төгрөгийн өр төлбөрүүдээс шалтгаалсан байна.

Урт хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэл 164,550.9 сая төгрөг болж, өмнөх оноос 163,743.2 сая төгрөгөөр өссөн нь төрийн болон орон нутгийн өмчөөр эх үүсвэрийг шийдвэрлүүлж хийсэн хөрөнгийн бүртгэлээс СТОУС-ын дагуу тайлагнан цаашид үлдсэн 1,025.5 сая төгрөг, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн "Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөлийн төсөл"-ийн зээлийн

төлбөр 45.9 сая ам.доллар буюу 163,525.4 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрөөс шалтгаалсан байна.

Эздийн өмчийн дансны 5,944.1 сая төгрөгийн бууралт нь тайлант үеийн алдагдлаас шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/12 дугаар тушаалаар “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2025 оны техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахдаа нийт орлогыг 116,086.3 сая төгрөгөөр, зардлыг 115,886.3 сая төгрөгөөр, 180.0 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоож, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 11,885.6 сая төгрөг тус тус баталжээ.

Эрчим хүчний сайдын 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/186 дугаар тушаалаар “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг тодотгохдоо нийт орлогыг 97,350.9 сая төгрөг, зардлыг 111,592.1 сая төгрөг, алдагдлыг 14,261.2 сая төгрөг байхаар төлөвлөж, хөрөнгө оруулалтын 84 арга хэмжээг 11,885.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тодотгосон байна.

Эрчим хүчний сайдын 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/273 дугаар тушаалаар 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг ахин тодотгохдоо нийт зардлыг 111,825.6 сая төгрөг, алдагдлыг 14,494.7 сая төгрөг байхаар тодотгож баталсан нь “Эрчис Монгол” ТӨХХК-с менежментийн зөвлөгөө авахаар төлсөн төлбөртэй холбоотой байна.

Гүйцэтгэлээр 98,876.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 104,820.3 сая төгрөгийн зардал гарган, 5,944.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тайлант онд тодотгосон төлөвлөгөөгөөр 14,261.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн ч 5,944.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь орлого төлөвлөснөөс 1,525.3 сая төгрөгөөр давж биелэн, зардал 7,005.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт орлогын гүйцэтгэл 98,876.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,525.3 сая төгрөгөөр буюу 1.6 хувиар давсан нь үйл ажиллагааны орлого 334.9 сая төгрөгөөр, үйл ажиллагааны бус орлого 1,190.4 сая төгрөгөөр давснаас шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 104,820.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 7,005.3 сая төгрөг буюу 4.1 хувийн дутуу гүйцэтгэлтэй байна.

Энэ нь тайлант оны үйлдвэрлэлийн хэмжээний өсөлттэй холбоотойгоор зардлыг хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна. Үүнд: түлш шатахууны зардлыг 1,770.4 сая төгрөгөөр, элэгдлийн зардлыг 614.8 сая төгрөгөөр, бусад тогтмол зардлыг 4,474.2 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/12 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар хөрөнгө оруулалтын 81 ажлыг 2025 онд 8,960.0 сая төгрөгөөр, 2026 онд 2,925.6 сая төгрөгөөр, нийт 11,885.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Эрчим хүчний сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/186 дугаар тушаалаар хөрөнгө оруулалтын 84 ажлыг 2025 онд 9,060.0 сая төгрөгөөр, 2026 онд 2,825.6 сая төгрөгөөр, нийт 11,885.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тодотгон баталсан байна.

Хүснэгт 2. Хөрөнгө оруулалтын хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөгөөр)

д/д	Зардлын төрөл	2025 оны төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт
		тоо	сая.төг	тоо	сая.төг	хувь
1	Их засварын ажил	26	8,960.40	25	8,413.60	98.1%
2	Техник зохион байгуулалтын арга хэмжээ	9	932.60	8	851.90	95.6%
3	Хөрөнгө оруулалт	49	1,992.60	46	1,517.00	95.1%
Нийт ИЗ, ТЗБАХ, ХО-н дүн		84	11,885.60	79	10,782.50	96.2%

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн 81 ажилд 11,885.6 сая төгрөгийг анх батлуулж, тодотголоор 11,885.6 сая төгрөгөөр 84 ажил төлөвлөснөөс, 2025 онд 11,329.7 сая төгрөгийн гэрээ хийж, 10,782.5 сая төгрөгийн гүйцэтгэлийг 4,425.2 сая төгрөгөөр санхүүжүүлж, 96.2 хувийн биелэлттэй байна.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээг төрөл тус бүрээр үзэхэд:

- Их засварын ажлаас үндсэн тоноглолын их засварын 3 нэр төрлийн ажлаас 3 ажил 100 хувийн гүйцэтгэлтэй, туслах тоноглолын 20 нэр төрлийн 23 ажлаас 19 нэр төрлийн 22 ажил 100 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж дууссан. 1 нэр төрлийн 1 ажил 50 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Техник зохион байгуулалт, арга хэмжээний 7 нэр төрлийн 9 ажил төлөвлөгдсөнөөс 8 ажил бүрэн хийгдэж дууссан. 1 ажил он дамнасан.
- Хөрөнгө оруулалтын 33 нэр төрлийн 49 ширхэг тоног төхөөрөмжөөс 30 нэр төрлийн 46 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, санхүүгийн бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Одгэрэл, О.Гантуяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах, дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва нар тус тус хэрэгжүүллээ.

"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 01/103 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн тайланд тусгагдсан нийт орлого 98,040.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,470.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу тухайн байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихын зэрэгцээ гарч болох эрсдэлийг төлөвлөгөө, гүйцэтгэлд тусгасан бөгөөд байж болох хувилбарыг түүвэрлэн авч горим сорил хэрэгжүүлэхэд гүйцэтгэх захирлын тушаал шийдвэргүй, үндэслэлгүйгээр баг, комисст ажилласан гишүүдэд сар болон жилийн үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 42.2 сая төгрөгийг олгосон, спортын арга хэмжээ зохион байгуулахад 6.2 сая төгрөгийг зарцуулсан зэрэг зөрчил илэрсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудсанд хөрөнгө зарцуулах 42 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.13-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8 дахь хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл болон дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд, мөн тэдгээрт өөрчлөлт оруулсан тухай бүрд өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ", Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 7.1-д "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ", 7.1.3-т "тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны хуулийн мэдээлсэн байдлын хэрэгжилт 83.8 хувь, хугацаа хоцролтын хэрэгжилт 100.0 хувьтай үнэлэгдсэн тул зөрчилтөйд тооцож албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлж, байгууллагын самбар болон цахим хуудсаар хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй тул зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2025 оны эхний 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл хөтөлж, шалгагдагч байгууллагад танилцуулсан.

Завсрын аудитаар нийт 561.2 сая төгрөгийн 9 зөрчил илэрснээс жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийн биелэлт хангагдаагүй тул тайлант оны буруу илэрхийлэлд оруулан тооцож 55.0 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч, 497.9 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 8.3 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоов.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болормaa, аудитор Ц.Одгэрэл, Ж.Наранчимэг нар гүйцэтгэж, нийт 741.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 26.2 сая төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 705.6 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 9.6 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн байна.

Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 01/1320 дугаар албан тоотоор ирүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	7	26.2	7	26.2	100.0%
Албан шаардлага	5	705.6	5	705.6	100.0%
Зөвлөмж	4	9.6	1	9.6	25.0%
Нийт дүн	16	741.4	13	741.4	81.3%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 81.3 хувьтай хэрэгжсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагч буюу Эрчим хүчний сайдад хамаарах асуудлын хүрээнд авч үзэхээр байна. Тухайлбал:

1. Менежментийн зөвлөгөө өгөх үйлчилгээг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр "Эрчист Монгол" ТӨХХК-д 256.9 сая төгрөгийг гэрээ дүгнэлгүй шилжүүлсэн байна.
2. Тус байгууллага нь нэр бүхий 5 компанитай худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй нэвтрүүлэг, контентын үйлчилгээ авах гэрээ байгуулж, анхан шатны баримтын бүрдэлгүй, гэрээг дүгнэлгүй 99.8 сая төгрөгийг 2025 оны 02 дугаар сарын 24-ны өдөр байгууллагын 4 арилжааны банкин дахь данснаас 20 удаагийн гүйлгээгээр шилжүүлсэн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 880.7 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс 28.7 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 540.1 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, 311.9 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж спортын арга хэмжээ зохион байгуулсан, анхан шатны баримтгүй зарцуулсан, томилолтын зардал илүү тооцож олгосон, сахилгын шийтгэлтэй ажилтнуудад урамшуулал олгосон зэрэг нийт 28.7 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлээгүй, худалдан авалтын гэрээг үндэслэлгүй сунгасан, тусгай зөвшөөрөлгүй аж ахуй нэгжийг нээлттэй тендерт шалгаруулсан, нэр бүхий 5 компанитай худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй нэвтрүүлэг, контентын үйлчилгээ авах гэрээ байгуулж, анхан шатны баримтын бүрдэлгүй, гэрээг дүгнэлгүй санхүүжилт олгосон, гүйцэтгэх захирлын тушаал шийдвэргүй, үндэслэлгүйгээр баг, комисст ажилласан гишүүдэд сар болон жилийн үр дүнгийн урамшуулалтай давхардуулан цалин олгосон зэрэг нийт 540.1 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

Тайлант онд бэлэн мөнгө олгохыг хүссэн өргөдлийг ерөнхий нягтлан бодогчоор цохуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2017 оны "Маягт, заавар батлах тухай" 347 дугаар тушаалын 2.2-т "Бэлэн мөнгө авах хүмүүс бэлэн мөнгө олгохыг хүссэн өргөдлийг асуулгын дагуу 1 хувь нөхөн бичиж, гарын үсгээ зурсны дараа дарга, нягтлан бодогчоор цохуулж, гарын үсэг зуруулан, бэлэн мөнгөний зарлагын баримт хавсаргахаар хариуцсан нягтлан бодогчид өгч, нярваас мөнгө авч, баримтын 1 хувийг няравт үлдээнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бэлэн мөнгө олгохыг хүссэн өргөдлийг ерөнхий нягтлан бодогчоор цохуулж байх.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт 2:

Менежментийн зөвлөгөө өгөх үйлчилгээг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр "Эрчист Монгол" ТӨХК-тай гэрээ байгуулж, гэрээг дүгнэлгүй 256.9 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4-т "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:", 84.4.1-д "хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх", 84.4.2-т "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх", 84.4.3-д "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4.1.23-д "'худалдан авах ажиллагаа' гэж бараа худалдан авах, түрээслэх, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах ажиллагааг төлөвлөх, тендер шалгаруулалтын аргыг сонгох, үнэлгээний хороо байгуулах, тендер шалгаруулалт зохион байгуулах, тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх ажиллагааг" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тендер шалгаруулалтыг хууль, журмын хүрээнд зохион байгуулж, гэрээ дүгнэсний дараа санхүүжилтийг 100 хувь олгож байх.

2. Анхан шатны баримт бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 3:

Жолоочийн тооцооны хуудсыг бүрэн гүйцэд бөглөдөггүй, тусгай зориулалтын болон хүнд машин механизмын түлшний тооцоог зарцуулсан хэмжээгээр, жижиг автомашины бензин шатахууны тооцоог мөнгөн дүнгээр тооцдоггүй явсан километрээр нь хяналт хэрэгжүүлдэг байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Жолоочийн тооцооны хуудсыг бүрэн гүйцэд бөглөж байх.

Илрүүлэлт 4:

Тус компани нь иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах ажлыг хангалтгүй хэрэгжүүлж, байгууллагын самбар болон цахим хуудсаар хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8 дахь хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл болон дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд, мөн тэдгээрт өөрчлөлт оруулсан тухай

бүрд өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ", Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1-д "Дараах байгууллага нийтийн мэдээлэл хариуцагч /цаашид "мэдээлэл хариуцагч" гэх/ байна.", 6.1.2-т "төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд", 8.4-д "Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байх.

Илрүүлэлт 5:

Тайлант онд байгуулсан зарим ажил гүйцэтгэх болон бараа худалдан авах гэрээний огноог өмнөх оноор, аймаг орон нутгийн нэрийг зөрүүтэй бичсэн, доторх агуулгад 2 өөр хуулийн этгээдийн нэрийг хольж оруулсан зэрэг эрх зүйн зөрчилтэй гэрээнүүд байгуулсан нь хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна. Мөн 1-р зуухны засварын ажлыг хүлээн авсан актын дүгнэлтэд 6-р зуухны засварын ажлын гүйцэтгэл 90%-тай байна гэж хольж бичсэн техникийн алдаанууд гаргасан нь анхан шатны баримтын үнэн зөвийг хангахгүй байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4-т "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:", 84.4.2-т "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зэрчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна:", 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Гэрээний хяналтыг сайжруулж, анхан шатны баримтын үнэн зөвийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/													
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
							Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцагаа тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шигжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	1	40.1					1	40.1				
Бэгэн мөнгө олгохыг хүссэн өргөдлийг ерөнхий нягтлан бодогчоос цохуулдаггүй байна.												
Жо тосчийн тосцооны хуудсыг бүрэн гүйцэд бөглөдөггүй, тусгай зориулалтын болон хүнд машин механизмын түлшний тооцог зарцуулсан хэмжээгээр, жижиг автомашинны бензин шатахууны тооцог мөнгөн дүнгээр тооцдоггүй явсан километрээр нь хяналт хэрэгжүүлдэг байна.												
Тайлант онд байгуулсан зарим ажил гүйцэтгэх болон бараа худалдан авах гэрээний огцоог өмнөх оноор аймаг орон нутгийн нэрийг зөрүүтэй бичсэн, доторх агуулгад 2 өөр хуулийн этгээдийн нэрийг хольж оруулсан зэрэг эрх зүйн зөрчилтэй гэрээнүүд байгуулсан нь хяналт хангалтгүй байхатай холбоотой байна.												

Мөнөхментийн зөвлөгөө өгөх үйлчилгээг худалдан авах ажиллагаа зохион байгуулалтыгээр "Эрчист Монгол" ТӨХХК-д 256.9 сая төгрөгийг гэрээ дүгнэлгүй шилжүүлсэн байна.	1	256.9				1	256.9				
Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 1631 нэр төрлийн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх ажлыг зохион байгуулаагүй байна.	1	-				1	-				
Тайлант онд нийлүүлэгдсэн "МВ цахилгаан хөдөлгүүр EP/25B-22", "Булгачийн цахилгаан хөдөлгүүр EP/25B-27" гэрээнүүдийн хугацааг үндэслэлгүй сунгасан байна.	1	198.1				1	198.1				
Төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөлгүй аж ахуй нэгжээр төмөр замын дэр модыг бетоноор солиулах ажлыг гүйцэтгүүлэн 200.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.	1	200.0				1	200.0				
Тус байгууллага нь нэр бүхий 5 компанитай худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туслаагүй нэвтрүүлэг, контентын үйлчилгээ авах гэрээ байгуулж, анхан шатны баримтын бүрдэлгүй, төрөөг дүгнэлгүй 99.8 сая төгрөгийг 2025 оны 02 дугаар сарын 24-ны өдөр байгууллагын 4 арилжааны банкинд дахь данснаас 20 удаагийн гүйлгээгээр шилжүүлсэн байна.	1	99.8				1	99.8				
Гүйцэтгэх захирлын тушаал шийдвэргүй, үндэслэлгүйгээр баг, комисст ажилласан гишүүдэд сар болон жилийн үр дүнгийн урамшуулалтай давахардуулан 42.2 сая төгрөгийг олгосон байна.	1	42.2				1	42.2				
Тайлант онд 4.9 сая төгрөгийн томилолтын зардлыг илүү олгосон байна.	1	4.9	1	4.9							
Анхан шатны баримтын бүрдэлгүй дараа тайлангаар 3.6 сая төгрөг зарцуулсан байна.	1	3.6	1	3.6							
Тус компани нь экспортын арга хэмжээ зохион байгуулахад 6.2 сая төгрөг зарцуулсан байна.	1	6.2	1	6.2							
Сахилпын шийтгэлтэй ажилтнуудад 14.0 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.	1	14.0	1	14.0							
Дүн	13	880.7	4	28.7	5	540.1	4	311.9			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс					
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудсанд хөрөнгө зарцуулах 42 шийдвэрийг мэдээлээгүй байна.	1	-		1	-		
Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Тус компани нь иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах ажлыг хангалтгүй хэрэгжүүлж, байгууллагын самбар болон цахим хуудсаар хуульд заасан мэдээллийг мэдээлээгүй байна.	1	-				1	-
Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчилж батлуулаагүй байна.	1	-		1	-		
Дүн	3	-		2	-	1	-



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,

Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033

Утас: (976) 7035 9826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.03.13 № 155
танай _____-ны № _____-т

“ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ
ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**2025 оны санхүүгийн тайлангийн
аудитын тухай**


Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитын тайлан, аудитын дүгнэлт болон аудитаар илэрсэн зөрчилд 28,653.8 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 540,143.1 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, 311,925.2 мянган 5 зөвлөмж өгч байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” гэж заасныг хэрэгжүүлж төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 30 хоногийн дотор, төлбөрийн актыг бүрэн барагдуулж, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2026 оны 03 дугаар 15 сарын

Дугаар 152/А1471118

Баян-Өндөр сум

ОРА-2026/004/НА-СТА-ТӨҮГ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сахилгын шийтгэлтэй ажилтнуудад 14,022,815 (Арван дөрвөн сая хорин хоёр мянга найман зуун арван таван) төгрөгийн урамшуулал олгосон байна.


Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4-т "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:", 84.4.1-д "хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх", 84.4.2-т "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх", 84.4.3-д "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн захирлын 2022 оны 06 дугаар сарын 10-ны А/77 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Ажилтнуудад сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.14-т "Сахилгын арга хэмжээ авагдсан ажилтны тухайн сарын үр дүнгийн нэмэгдэл цалинг 100% хасч тооцно. Арга хэмжээ авагдсан ажилтан ээлжийн амралт, өвчтэй чөлөөтэй, бусад шалтгааны улмаас арга хэмжээ тооцох хугацаанд дутуу (тухайн сарын цагийн балансын 80%-д хүрээгүй) ажилласан бол нөхөж үр дүнг хасч тооцно. Үндсэн цалинг бууруулах арга хэмжээнд нэгэн адил хамаарна" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

612511482

1. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК нь сахилгын шийтгэлтэй ажилтнуудад олгосон 14,022,815 (Арван дөрвөн сая хорин хоёр мянга найман зуун арван таван) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Бат-Эрдэнэ), ерөнхий нягтлан бодогч, санхүү, бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Зулцэцэг) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛГҮХ АУДИТОР:		П.ПҮРЭВЛХАГВА
АУДИТЫН МЕНЕЖЕР:		Б.БУЯН-УНДРАХ
АУДИТОР:		Ц.ОДГЭРЭЛ
АУДИТОР:		О.ГАНТУЯА

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-9826



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2026 оны 03 дугаар 15 сарын

Дугаар 153/А1471118

Баян-Өндөр сум

ОРА-2026/004/НА-СТА-ТӨҮГ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд анхан шатны баримтын бүрдэлгүй 3,569,430 (Гурван сая таван зуун жаран есөн мянга дөрвөн зуун гучин) төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК нь анхан шатны баримтын бүрдэлгүй олгосон 3,569,430 (Гурван сая таван зуун жаран есөн мянга дөрвөн зуун гучин) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Эрдэнэтийн дулааны

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-9826

цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Бат-Эрдэнэ), ерөнхий
нягтлан бодогч, санхүү, бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Зулцэцэг)
нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:  П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР:  Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР:  Ц.ОДГЭРЭЛ

АУДИТОР:  О.ГАНТУЯА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2026 оны 03 дугаар 15 сарын

Дугаар 154/А1471118
ОРА-2026/004/НА-СТА-ТӨЧГ

Баян-Өндөр сум

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 4,861,500 (Дөрвөн сая найман зуун жаран нэгэн мянга таван зуун) төгрөгийн томилолтын зардлыг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.2-д "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ:", 2.2.1-д "унааны зардал", 2.2.2-т "байрны зардал", 2.2.3-д "хоолны зардал", 2.4-д "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно", Сангийн сайдын 2024 оны "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" А/52 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК нь илүү олгосон томилолтын зардал 4,861,500 (Дөрвөн сая найман зуун жаран нэгэн мянга таван зуун) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;

612511491

2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Бат-Эрдэнэ), ерөнхий нягтлан бодогч, санхүү, бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Зулцэцэг) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР:  П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН

МЕНЕЖЕР:  Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР:  Ц.ОДГЭРЭЛ

АУДИТОР:  О.ГАНТУЯА

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-9826



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2026 оны 03 дугаар 15 сарын

Дугаар 155/А1471118

Баян-Өндөр сум

ОРА-2026/004/НА-СТА-ТӨҮГ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус компани нь спортын арга хэмжээ зохион байгуулахад 6,200,000 (зургаан сая хоёр зуун мянган) төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4-т "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:", 84.4.1-д "хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3.1-д "Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна:", 3.1.3-д "банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК нь илүү олгосон томилолтын онд 6,200,000 (зургаан сая хоёр зуун мянган) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;

612511485

2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Бат-Эрдэнэ), ерөнхий нягтлан бодогч, санхүү, бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Зулцэцэг) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ
АУДИТОР: П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР: Ц.ОДГЭРЭЛ

АУДИТОР: О.ГАНТУЯА

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-9826



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 дугаар 15 сарын

Дугаар 166/А1471118

Баян-Өндөр сум

ОРА-2026/004/НА-СТА-ТӨЧ

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирлын тушаал шийдвэргүй, баг, комисст ажилласан ажилчдад сар болон жилийн үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 42,234,859 (Дөчин хоёр сая хоёр зуун гучин дөрвөн мянга найман зуун тавин есөн) төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4-т "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:", 84.4.1-д "хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх", 84.4.2-т "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх", 84.4.3-д "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3.1-д "Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна", 3.1.3-д "банк, санхүүгийн болон бусад салбарын төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтан", 10.2-т "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

012509516

1. Сар болон жилийн үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон зөрчлийг давтан гаргахгүй байж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Бат-Эрдэнэ), санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Зулцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЭХ
АУДИТОР: П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР: Ц.ОДГЭРЭЛ

АУДИТОР: О.ГАНТУЯА

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 дугаар 15 сарын

Дугаар 167/А1471118

Баян-Өндөр сум

ОРА-2026/004/НА-СТА-ТӨҮГ

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь нэр бүхий 5 компанитай худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй нэвтрүүлэг, контентын үйлчилгээ авах гэрээ байгуулж, анхан шатны баримтын бүрдэлгүй, гэрээг дүгнэлгүй 99,800,000 (Ерэн есөн сая найман зуун) төгрөгийг 2025 оны 02 дугаар сарын 24-ны өдөр байгууллагын 4 арилжааны банкин дахь данснаас 20 удаагийн гүйлгээгээр шилжүүлсэн байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4-т "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:", 84.4.1-д "хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх", 84.4.2-т "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх", 84.4.3-д "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

612509713

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй, нэвтрүүлэг, контент хийх гэрээг дүгнэлгүй 99,800.0 мянган төгрөгийг олгосон зөрчлийг дахин давтахгүй байж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Бат-Эрдэнэ), санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Зулцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРВЭЛТЭХ
АУДИТОР:  П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР:  Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР:  Ц.ОДГЭРЭЛ

АУДИТОР:  О.ГАНТУЯА

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 дугаар 15 сарын

Дугаар 168/А1471118

Баян-Өндөр сум

ОРА-2026/004/НА-СТА-ТӨҮГ

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөлгүй аж ахуй нэгжээр төмөр замын дэр модыг бетоноор солиулах ажлыг гүйцэтгүүлэн 200,000,000 (Хоёр зуун сая) төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Энэ нь өмөр замын тээврийн тухай хуулийн 14.1-д "Төмөр замын тусгай зөвшөөрөл дараах төрөлтэй байна:", 14.1.3-д "төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, тэдгээрийн эд анги үйлдвэрлэх, угсрах, засварлах", 22.1-д "Төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд захиалагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр холбогдох хууль тогтоомж, төмөр замын тээврийн дүрэм, журам, техникийн зохицуулалт, стандартын дагуу барьж гүйцэтгэнэ", Компанийн тухай хуулийн 84.4-т "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:", 84.4.1-д "хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх", 84.4.2-т "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх", 84.4.3-д "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

612509521

1. Тусгай зөвшөөрөлгүй аж ахуй нэгжээр төмөр замын дэр модыг бетоноор солиулах ажлыг гүйцэтгүүлсэн зөрчлийг дахин давтахгүй байж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Бат-Эрдэнэ), санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Зулцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:  Т.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР:  Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР:  Ц.ОДГЭРЭЛ

АУДИТОР:  О.ГАНТУЯА

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 дугаар 15 сарын

Дугаар 169/А1471118

Баян-Өндөр сум

ОРА-2026/004/НА-СТА-ТӨЧ

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 1631 нэр төрлийн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх ажлыг зохион байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаас өгсөн өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлж, элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн нийт 1631 нэр төрлийн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх ажлыг зохион байгуулаагүй зөрчлийг дахин давтахгүй байж, биелэлтийг 2026

612509528

оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Бат-Эрдэнэ), санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Зулцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР: П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН

МЕНЕЖЕР: Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР: Ц.ОДГЭРЭЛ

АУДИТОР: О.ГАНТУЯА

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 дугаар 15 сарын

Дугаар 170/А1471118
ОРА-2026/004/НА-СТА-ТВЧ

Баян-Өндөр сум

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийлүүлэгдсэн "МВ цахилгаан хөдөлгүүр EP/25Б-22", "Бутлагчийн цахилгаан хөдөлгүүр EP/25Б-27" гэрээнүүдийн хугацааг үндэслэлгүйгээр сунгасан байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 84.4-т "Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:", 84.4.1-д "хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх", 84.4.2-т "үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх", 84.4.3-д "компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Бат Илч ХХК-тай байгуулсан 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн EP/25Б-22, EP/25Б-27 дугаарын гэрээний 7.3-д "Давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгаанаар гэрээний хугацааг сунгах бол гэрээний хүчинтэй байх хугацаанд багтаан албан бичгээр мэдэгдэх ба тус хугацаанд багтаан мэдэгдээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн алдангийг гэрээний 5.5-д заасан хувь хэмжээгээр тооцно", 7.4-д "Гэрээг сунгахад нөлөөлсөн шалтгаан, үүссэн нөхцөл байдлыг баримтаар нотолж ирүүлэх ба эрх бүхий байгууллагын албан бланк, тамга тэмдэгээр баталгаажсан байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.8-д

612509526

“байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Гэрээний хугацааг үндэслэлгүй сунгасан зөрчлийг дахин давтахгүй байж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Бат-Эрдэнэ), санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Зулцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮНЭХ
АУДИТОР:  П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР:  Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР:  Ц.ОДГЭРЭЛ

АУДИТОР:  О.ГАНТУЯА

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2026 оны 03 дугаар 15 сарын

Дугаар 171/А1471118
ОРА-2026/004/НА-СТА-ТБЧГ

Баян-Өндөр сум

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчилж батлуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:", 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаас өгсөн өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчилж батлуулаагүй зөрчлийг дахин давтахгүй байж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955

612511194

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Бат-Эрдэнэ), санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Зулцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР: П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР: Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР: Ц.ОДГЭРЭЛ

АУДИТОР: О.ГАНТУЯА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 дугаар 15 сарын

Дугаар 172/А1471118

Баян-Өндөр сум

ОРА-2026/004/НА-СТА-ТӨҮГ

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны цахим хуудсанд хөрөнгө, мөнгө зарцуулах 42 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.13-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8 дахь хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл болон дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд, мөн тэдгээрт өөрчлөлт оруулсан тухай бүрд өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ”, Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ”, 7.1.3-т “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Аудитаас өгсөн өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлж, шилэн дансны цахим хуудсанд хөрөнгө, мөнгө зарцуулах 42 шийдвэрийг мэдээлээгүй зөрчлийг

дахин давтахгүй байж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Бат-Эрдэнэ), санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга (Б.Зулцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРҮҮЛЭХ
АУДИТОР:  П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР:  Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР:  Ц.ОДГЭРЭЛ

АУДИТОР:  О.ГАНТУЯА

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэн булаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955